



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/124

Мандал

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. 2024 оны 10 дугаар сарын 17-нд 1 дүгээр багийн гол модны өвөрт амьдардаг Жүгдэр овогтой Буянхишгийн орон сууц байшин шатсан тул шатсан эд материалыг үнэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Цэндбаяр (Гамшгийн асуудал хариуцсан ажилтан)
Гишүүд: Л.Шигтов (Жолооч)
Д.Дамдиндорж (Мал эмнэлгийн улсын байцаагч)
Д.Түвшинбаяр (Тархвар зүйч)
Нарийн бичгийн дарга: Х.Цэнд-Очир (6-р багийн засаг дарга)

2. Шатсан эд хөрөнгийг зах зээлийн үнэ ханшаар үнэлэн гаргахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (С.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА

